

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/219/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegi@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 51-261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшсүрэн Утас: 51-261740 Цахим хаяг: teqshsurenb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3.Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	22
5.2 Албан шаардлага.....	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
МУЗГ	Монгол улсын засгийн газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮТББ	Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЦҮЗГ	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/316
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 283,286.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал,

- Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс 102,764.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагаагүй, төсвийн төсөлд төлөвлөөгүй, батлуулаагүй зардлыг санхүүжүүлж 88,336.0 мянган төгрөгийн зардал гаргасан;
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 48,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлээгүй;
- Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, тэвчиж болох нийт 40,500.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн.

Дээр дурдсан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.1.8, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсөв захирагчийн 2025 оны санхүүгийн байдлын тайланд 237,892.6 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь дараа жилийн төсөвт төлөвлөгдөөгүй зардал гаргах, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлага алдагдах эрсдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Агентлагийн бүтцэд хэлтэс хэлбэрээр батлагдсан Улсын бүртгэлд байгууллагын регистрийн дугаар, гэрчилгээ аваагүй тус агентлагийн харьяа нийслэл, орон нутгийн хэлтсийн дарга нарыг Нийтийн ил тод байдлын тухай хуулиар сайд, хэлтсийн албан хаагчдыг хэлтсийн дарга томилж, чөлөөлж байгаа нь төсвийн байгууллагын дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог бууруулж байна.

Бусад асуудал

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн болно.

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	371,435,291.18	308,328,310.19
33	АВЛАГА	27,576,022.05	3,685,883.50
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	394,395.53	3,685,883.50
33300	Татаас, санхүүжилтийн авлага	24,303,982.27	-
33500	Бусад авлага	2,877,644.25	-
33510	Байгууллагаас авах авлага	2,877,644.25	-
34	УРЬДЧИЛГАА	42,912,833.34	17,989,067.00
34600	Урьдчилж гарсан зардал	42,912,833.34	17,989,067.00
35	БАРАА МАТЕРИАЛ	300,946,435.79	286,653,359.69
35400	Хангамжийн материал	300,946,435.79	286,653,359.69
35410	Бичиг хэргийн материал	12,613,042.61	4,377,748.51
35420	Аж ахуйн материал	35,586,445.00	34,036,990.00
35440	Түлш, шатах тослох материал	10,236,627.00	-
35470	Бусад хангамжийн материал	242,510,321.18	248,238,621.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	783,133,482.96	644,798,453.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	783,133,482.96	644,798,453.26
39200	Биет хөрөнгө	775,015,482.96	589,066,953.27
39203	Авто-тээврийн хэрэгсэл	48,000,000.00	48,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(41,333,333.55)	(48,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	856,709,324.00	856,709,324.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(266,902,304.26)	(430,156,034.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	235,944,000.00	242,094,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,402,203.23)	(79,580,335.87)
39300	Биет бус хөрөнгө	8,118,000.00	55,731,499.99
39303	Бусад биет бус хөрөнгө	11,880,000.00	253,680,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,762,000.00)	(197,948,500.01)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,154,568,774.14	953,126,763.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,955,642.34	237,892,627.15
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,955,642.34	237,892,627.15
41300	Өглөг	23,955,642.34	237,892,627.15
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	23,534,331.07	-
41360	Бусад өглөг	421,311.27	237,892,627.15
41361	Байгууллагад төлөх өглөг	-	237,892,627.15
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	421,311.27	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,130,613,131.80	715,234,136.30
51	Засгийн газрын хувь оролцоо	1,130,613,131.80	715,234,136.30
51200	Хуримтлагдсан үр дүн	1,130,613,131.80	715,234,136.30
51210	Өмнөх үеийн үр дүн	1,195,343,124.38	1,130,613,131.80
51220	Тайлант үеийн үр дүн	(64,729,992.58)	(415,378,995.50)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1,154,568,774.14	953,126,763.45

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,826,817,988.95	7,436,650,883.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,309,520.45	7,436,650,883.39
120	Нийтлэг татварын бус орлого	8,309,520.45	55,224,999.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,309,520.45	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,642,854.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,666,666.45	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	55,224,999.99
122	Тусламжийн орлого	-	7,381,425,883.40
1221	Хандив тусламж /дотоод/	-	7,381,425,883.40
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	7,198,990,700.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	7,198,990,700.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	182,435,183.40
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	182,435,183.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,818,508,468.50	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,757,622,560.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,757,622,560.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,885,908.50	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,885,908.50	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,891,547,981.53	7,852,029,878.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,891,547,981.53	7,852,029,878.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,282,715,958.85	6,825,729,635.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,509,666,154.82	4,704,067,397.91
210101	Үндсэн цалин	2,726,388,761.55	2,813,352,285.75
210102	Нэмэгдэл	701,743,805.09	788,446,112.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	718,001,869.99	765,337,000.00
210104	Урамшуулал	363,531,718.19	336,932,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	562,450,300.00	588,626,464.62
210201	Тэтгэврийн даатгалын зардал	382,466,300.00	406,004,260.70
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	44,996,000.00	48,044,066.19
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	22,498,000.00	23,600,293.30
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	22,498,000.00	29,152,042.47
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	89,992,000.00	81,825,801.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	539,624,024.12	517,492,950.00
210301	Гэрэл, цахилгаан	32,003,983.11	83,243,000.00
210302	Түлш, халаалт	63,933,500.00	-
210303	Цэвэр, бохир ус	-	84,544,800.00
210304	Байрны түрээс	443,686,541.01	349,705,150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	442,497,577.48	406,605,443.50
210401	Бичиг хэрэг	103,288,481.30	73,640,045.50
210402	Тээвэр, шатахуун	8,317,824.40	10,236,627.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	249,179,876.88	277,302,466.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	23,394,850.00	26,370,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	58,316,544.90	19,056,305.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,470,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	5,470,000.00
2107	Томилолт, зочны зардал	365,804,824.00	55,800,405.00

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	365,804,824.00	55,800,405.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	602,483,238.40	316,356,944.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	565,142,744.87	293,635,213.34
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,849,293.53	16,012,833.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,491,200.00	6,708,898.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	260,189,840.03	231,310,029.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,960,000.00	31,600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	226,229,840.03	199,710,029.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	608,832,022.68	1,026,300,243.23
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	905,897,672.33
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	905,897,672.33
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	905,897,672.33
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	905,751,467.33
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	146,205.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	118,576,237.50	120,402,570.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	118,576,237.50	120,402,570.90
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	490,255,785.18	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	490,255,785.18	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(64,729,992.58)	(415,378,995.50)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(64,729,992.58)	(415,378,995.50)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,820,572,633.77	7,405,308,554.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,064,165.27	7,405,308,554.40
120	Нийтлэг татварын бус орлого	2,064,165.27	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,642,854.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,642,854.00	-
120009	Бусад орлого	421,311.27	-
122	Тусламжийн орлого	-	7,405,308,554.40
1221	Хандив тусламж /дотоод/	-	7,405,308,554.40
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	7,198,990,700.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	7,198,990,700.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	206,317,854.40
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	40,895,000.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	137,687,844.40
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	27,735,010.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,818,508,468.50	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,757,622,560.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,757,622,560.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,885,908.50	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,885,908.50	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,786,528,709.77	7,402,758,554.40

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,786,528,709.77	7,402,758,554.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,147,762,704.82	6,376,458,311.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,482,680,193.42	4,725,794,958.55
210101	Үндсэн цалин	2,572,893,264.31	2,650,859,457.93
210102	Нэмэгдэл	828,597,873.33	979,149,797.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	717,722,551.69	758,853,702.91
210104	Урамшуулал	363,466,504.09	336,932,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	562,450,300.00	588,626,464.62
210201	Тэтгэврийн даатгалын зардал	382,466,300.00	406,004,260.70
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	44,996,000.00	48,044,066.19
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	22,498,000.00	23,600,293.30
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	22,498,000.00	29,152,042.47
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	89,992,000.00	81,825,801.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	512,625,674.12	476,526,900.00
210301	Гэрэл, цахилгаан	37,926,988.72	83,243,000.00
210303	Цэвэр, бохир ус	155,808,489.00	84,544,800.00
210304	Байрны түрээс	318,890,196.40	308,739,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	251,008,808.28	271,552,700.00
210401	Бичиг хэрэг	103,367,095.09	49,687,150.00
210402	Тээвэр, шатахуун	18,554,451.40	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,767,096.79	170,319,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,308,400.00	26,370,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,011,765.00	25,176,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,497,700.00	6,345,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,497,700.00	6,345,000.00
2107	Томилолт, зочны зардал	192,041,063.00	55,800,405.00
210702	Дотоод албан томилолт	192,041,063.00	55,800,405.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	690,069,205.00	220,211,883.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	633,589,205.00	185,057,783.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	46,592,900.00	25,202,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,887,100.00	9,952,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	444,389,761.00	31,600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	351,323,761.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93,066,000.00	31,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	638,766,004.95	1,026,300,243.23
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	905,897,672.33
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	905,897,672.33
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	905,897,672.33
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	905,751,467.33
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	146,205.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,206,237.50	120,402,570.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	124,206,237.50	120,402,570.90
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	514,559,767.45	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	490,677,096.45	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	23,882,671.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	34,043,924.00	2,550,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	34,043,924.00	2,550,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,043,924.00	2,550,000.00

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2200	Дотоод эх үүсвэрээр	34,043,924.00	2,550,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,043,924.00	2,550,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(34,043,924.00)	(2,550,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,195,343,124.38	1,195,343,124.38
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,195,343,124.38	1,195,343,124.38
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(64,729,992.58)	(64,729,992.58)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,130,613,131.80	1,130,613,131.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,130,613,131.80	1,130,613,131.80
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(415,378,995.50)	(415,378,995.50)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	715,234,136.30	715,234,136.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,366,099,800.00	6,293,239,232.67	1,072,860,567.33	85.4
12	Татварын бус орлого	7,366,099,800.00	6,293,239,232.67	1,072,860,567.33	85.4
122	Тусламжийн орлого	7,366,099,800.00	6,293,239,232.67	1,072,860,567.33	85.4
122005	Төсвөөс санхүүжих	7,366,099,800.00	6,293,239,232.67	1,072,860,567.33	85.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,366,099,800.00	6,293,239,232.67	1,072,860,567.33	85.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,366,099,800.00	6,293,239,232.67	1,072,860,567.33	85.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,364,099,800.00	6,291,239,232.67	1,072,860,567.33	85.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,510,275,600.00	4,706,509,685.05	803,765,914.95	85.4
210101	Үндсэн цалин	2,768,333,300.00	2,645,461,755.11	122,871,544.89	95.6
210102	Нэмэгдэл	1,795,301,900.00	965,262,227.03	830,039,672.97	53.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	501,653,100.00	758,853,702.91	(257,200,602.91)	151.3
210104	Урамшуулал	444,987,300.00	336,932,000.00	108,055,300.00	75.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	706,545,000.00	588,626,464.62	117,918,535.38	83.3
210201	Тэтгэврийн даатгал	480,526,000.00	406,004,260.70	74,521,739.30	84.5
210202	Тэтгэмжийн даатгал	56,532,800.00	48,044,066.19	8,488,733.81	85.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,262,200.00	23,600,293.30	4,661,906.70	83.5
210204	Ажилгүйдлийн даатгал	28,244,800.00	29,152,042.47	(907,242.47)	103.2
210205	Эрүүл мэндийн даатгал	112,979,200.00	81,825,801.96	31,153,398.04	72.4

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	476,526,900.00	476,526,900.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	83,243,000.00	83,243,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	84,544,800.00	84,544,800.00	-	100.0
210304	Байрны түрээс	308,739,100.00	308,739,100.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	421,726,700.00	271,552,700.00	150,174,000.00	64.4
210401	Бичиг хэрэг	87,460,300.00	49,687,150.00	37,773,150.00	56.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	270,319,400.00	170,319,400.00	100,000,000.00	63.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,571,700.00	26,370,000.00	5,201,700.00	83.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,375,300.00	25,176,150.00	7,199,150.00	77.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,345,000.00	6,345,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,345,000.00	6,345,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	38,950,400.00	38,950,400.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	38,950,400.00	38,950,400.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,130,200.00	171,128,083.00	1,002,117.00	99.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,655,000.00	135,973,983.00	681,017.00	99.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,514,800.00	25,202,000.00	312,800.00	98.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,960,400.00	9,952,100.00	8,300.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,600,000.00	31,600,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,600,000.00	31,600,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	158	158	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	124	127	(3)	102.4
620003	Үйлчлэх ажилтан	33	30	3	90.9
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	154	-	154	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	-	9	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	142	-	142	-
650013	УТҮГ	3	-	3	-

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		206,317,854.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		206,317,854.40
122	Тусламжийн орлого		206,317,854.40
1221	Хандив тусламж /дотоод/		206,317,854.40
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		206,317,854.40
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		40,895,000.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		137,687,844.40
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		27,735,010.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		206,317,854.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		206,317,854.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		87,769,078.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		19,285,273.50
210101	Үндсэн цалин		5,397,702.82
210102	Нэмэгдэл		13,887,570.68
2107	Томилолт, зочны зардал		16,850,005.00
210702	Дотоод албан томилолт		16,850,005.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		51,633,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		51,633,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		118,402,570.90
2132	Бусад урсгал шилжүүлэг		118,402,570.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		118,402,570.90
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэгийн зардал		146,205.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		-
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		-
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь дэвшилтэт технологи, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх замаар “Цахим Үндэстэн” болох ажлыг дэмжин, төрийн цахим шилжилтийг хэрэгжүүлэх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд,

- Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх байршлын судалгаа хийж, үйлчилгээний цэгийг шинээр байгуулах, өөрчлөх, салбар, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах;
- Төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
- Үйлчилгээний салбар, нэгж, төрийн үйлчилгээний нэгдсэн системээр ирсэн хүсэлтийг шалгах, үйл ажиллагааг зохион байгуулах, шийдвэрлэж хариу өгөх;
- Хэрэглэгчийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх, хэрэглэгчдийн үйлчилгээ авах мэдлэг ур чадварыг сайжруулах, сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлэх;
- Төрийн үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах судалгаа хийх, дахин загварчлах, боловсронгуй болгох санал боловсруулж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах;
- Төрийн үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх, үйлчилгээг хүргэх ажилтнуудыг сургах, мэргэшүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь цахим хөгжлийг дэмжих Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль ба тэдгээрт хамаарах журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд,

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын баталсан холбогдох журам зааварт өөрчлөлт орсон байна.
- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны “Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмж батлах тухай” 108 дугаар тогтоол;

Байгууллагын удирдлагуудын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/54 дүгээр тушаалаар баталсан харьяа төсөвт байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтлах “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 201,441.9 мянган төгрөгөөр буюу 21.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	27,576.0	3,685.9	(23,890.1)
Урьдчилгаа	42,912.8	17,989.1	(24,923.7)
Бараа материал	300,946.4	286,653.4	(14,293.0)
Үндсэн хөрөнгө	783,133.5	644,798.4	(138,335.1)
Нийт хөрөнгө	1,154,568.7	953,126.8	(201,441.9)
Өр төлбөр	23,955.6	237,892.6	213,937.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,130,613.1	715,234.2	(415,378.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,154,568.7	953,126.8	(201,441.9)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдууд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 3,685.9 мянган төгрөг болж өмнөх оноос 23,890.1 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн нэмэгдлийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас, санхүүжилтийн авлагаар бүртгэсэн 23,882.7 мянган төгрөг, өмнөх онд үүссэн бусад авлага 3,693.3 мянган төгрөг, нийт 27,576.0 мянган төгрөгийн авлага барагдсанаас шалтгаалсан бөгөөд тайлант онд цалингийн тооцооллын зөрүүгээс үүссэн 3,685.9 мянган төгрөгийн ажилтнуудаас авах авлага бүртгэлтэй;
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 17,989.1 мянган төгрөг болж өмнөх оноос 24,923.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд худалдан авч урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 47,535.4 мянган төгрөгийн үйлдлийн систем болон вирусны программын лицензийн эрхийг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснээс шалтгаалан

буурсан бол тайлант онд худалдан авсан 3 лицензийн дараа онд ногдох 17,989.1 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал бүртгэлтэй;

- Бараа материалын дансны үлдэгдэл 286,653.4 мянган төгрөг болж өмнөх оноос 14,293.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 57,972.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 318.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 26,527.3 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 180.0 мянган төгрөгийн түлш шатах тослох материал худалдан авч, бусад 9,658.4 мянган төгрөгийн бараа материал, нийт 94,656.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 108,949.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас голлон нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 644,798.4 мянган төгрөг болж өмнөх оноос 138,335.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд нэмэгдсэн 247,950.0 мянган төгрөгийн хөрөнгө болон 386,285.0 мянган төгрөгийн элэгдлийн зөрүү байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 6,150.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А-1/2311 албан тоотоор 241,800.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 186,575.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй www.shilen.gov.mn, opendata.gov.mn системүүдийг ЦХИХХЯ-наас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 237,892.6 мянган төгрөг болж өмнөх оноос 213,937.0 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд үүссэн шуудан холбооны 106,983.1 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн түрээсийн 74,464.5 мянган төгрөг, байрны түрээсийн 40,996.1 мянган төгрөг, бараа материалын 11,658.4 мянган төгрөг, хөрөнгийн 3,600.0 мянган төгрөг, НДШ-ийн 220.6 мянган төгрөг, нийт 34 аж ахуйн нэгжийн 237,922.7 мянган төгрөгийн өр төлбөрийг бүртгэсэн нь голлон нөлөөлсөн;
- Засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/ 715,234.2 мянган төгрөг болж өмнөх оноос 415,378.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлын санхүүжүүлэх эх үүсвэрийг 15,372,006.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас байр ашиглалттай холбоотой зардлыг 2,094,531.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,553,781.3 мянган төгрөг, ажиллагсадтай холбоотой зардлыг 1,284,817.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,073,486.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 133,584.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 332,397.8 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 283,500.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллыг 31,100.0 мянган төгрөг, нийт 6,787,199.5 мянган төгрөгөөр бууруулж 8,584,806.5 мянган төгрөгөөр баталсан байгаа нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвөөс бараа, ажил үйлчилгээний зардлыг 1,170,706.7 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 48,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан тодотгож, 7,366,099.8 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Эд хогшил, урсгал засварын зардлыг 386,055.0 мянган төгрөг, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллыг 356,823.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хураамжийг 297,908.8 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 58,425.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 54,823.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллыг 48,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 15,010.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 1,102.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 557.1 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 7,366,099.8 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр 7,198,990.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 6,293,239.2 мянган төгрөгийг зарцуулж, 905,751.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,293,239.2 мянган төгрөг буюу 85.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 803,765.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 117,918.6 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлын 150,174.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,002.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71302	Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц	7,366,099.8	6,293,239.2	1,072,860.6	85.4
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	7,293,099.8	6,220,239.2	1,072,860.6	85.3
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,000.0	2,000.0	-	100.0
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	71,000.0	71,000.0	-	100.0

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу Төрийн цахим үйлчилгээний, зохицуулалтын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/66 дугаар тушаалаар газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн орон тоог 158 болгон 9 хувиар бууруулсан байна.

Төрийн цахим үйлчилгээний, зохицуулалтын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар газрын албан хаагчдын хоолны зардлыг ажлын нэг өдөрт 30.0 мянган төгрөг, унааны зардлыг 3.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Тайлант онд албан хаагчдын сэтгэл зүй программын сургалтад 15,000.0 мянган төгрөг, процессын дахин инжерчлэл сургалтад 16,600.0 мянган төгрөг, нийт 31,600.0 мянган төгрөгийн сургалтыг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, санхүүжүүлсэн байна.

Байгууллагын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа санхүү бүртгэлийн 11,880.0 мянган төгрөгийн программ, ЦХИХХЯ-наас ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А-1/2311 албан тоотгоор 241,800.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 186,575.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй www.shilen.gov.mn, opendata.gov.mn системүүд бүртгэлтэй байна. Мөн байгууллагын дотооддоо бүтээсэн улсын хэмжээний нийт байгууллагуудын программын бүртгэл ашиглалтыг нэгтгэсэн services.khurdan.gov.mn программыг данс бүртгэлд үнэлж, тусгаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд НҮБ"-аас (DEMOSC) төслийн хүрээнд 102,730.0 мянган төгрөг, Төрийн цахим үйлчилгээний орон нутаг дахь ажилчдад “Нутгийн дэм” 113,805.2 мянган төгрөг, өмнөх оны татаас санхүүжилтийн авлагаас 23,882.7 мянган төгрөг, нийт 240,417.9 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдсэн байна.

Гүйцэтгэлээр (DEMOSC) төслийн хүрээнд хурал цуглаан зохион байгуулахад 51,633.8 мянган төгрөг, дотоод албан томилолтод 16,850.0 мянган төгрөг, орон нутагт ажиллаж буй нийт албан хаагчдын нэмэгдэл цалингийн зардалд 137,687.9 мянган төгрөг нийт 206,171.7 мянган төгрөгийг зарцуулж, НҮБ"-аас (DEMOSC) төслийн санхүүжилтээр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хугацаанд нь зохион байгуулж чадаагүйгээс 34,100.0 мянган төгрөгийг санхүүжүүлэгч байгууллагад, тайлант оны зарцуулаагүй үлдэгдэл 146.2 мянган төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргаар батлуулж, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 307,100.0 мянган төгрөгийн 2 худалдан авалт, ерөнхий гэрээний аргаар 76,000.0 мянган төгрөгийн 1 худалдан авалт, харьцуулалтын аргаар 290,269.0 мянган төгрөгийн 5 худалдан авалт, шууд худалдан авалтын аргаар 242,306.0 мянган төгрөгийн 13 худалдан авалт зохион байгууллахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 326,841.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 178,920.0 мянган төгрөгийн ХУРДАН цэгийн сүлжээний аюулгүй байдлыг хангах үйлчилгээ нэвтрүүлэх ажил;
- Харьцуулалтын аргаар 63,800.0 мянган төгрөгийн ХУРДАН цэгийн сүлжээний аюулгүй байдлыг хангах үйлчилгээ нэвтрүүлэх ажил;
- Шууд худалдан авалтын аргаар 84,121.0 мянган төгрөгийн сургалт судалгаа, контент, бараа, ажил үйлчилгээг худалдан авч бэлтгэсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах урсгал зардал, худалдан авах ажиллагаа, авлага, өглөг, цалин, Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитор Т.Баасанцэнд, Б.Тэгшсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/129 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурийг тодорхойлохдоо байгууллагын 2024 оны аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 7,891,548.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 78,915.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 7,852,029.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 13.6 хувиар буурсан нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 40,500.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгөв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 549,853.0 мянган төгрөгийн нийт 3 зөрчил илэрснээс 549,853.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлэхээр, 1 зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,770,182.6 мянган төгрөгийн зардлын 66 гүйлгээ, 9,477,423.2 мянган төгрөгийн орлогын 18 гүйлгээг цаг хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой

Илрүүлэлт 1: Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/129 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлангийн иж бүрдэлд төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайлан болон хуулиар баталсан бусад холбогдох тайлан мэдээг ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:", 54.5.1-т "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/", 54.5.3-т "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл", 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/", 54.5.5-т "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөв захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулиар заагдсан иж бүрдлээр Үндэсний аудитын газарт ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагаагүй албан хаагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Худалдан авалтыг хугацаанд нь зохион байгуулж чадаагүйгээс НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн төслийн санхүүжилтээс 34,100.0 мянган төгрөг, улсын төсвөөс 515,753.0 мянгөн төгрөг, нийт 549,853.0 мянган төгрөгийн шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч чадалгүй төсвийг буцаан татуулсан байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38-д "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд, хариуцлагатай зохион байгуулж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт 3: Агентлагийн бүтцийн нэгж 21 аймагт салбартай бөгөөд салбар бүрд 3–5 үйлчилгээний ажилтан ажилладаг. Тус ажиллагсад нь цахим хөгжил, бодлогын чиглэлээр иргэдэд мэдээлэл түгээх ажлыг гүйцэтгэх боломжтой байхад үндсэн салбарын ажилтнуудыг орон нутагт мэдээлэл түгээх зорилгоор дотоод томилолтоор олон удаа явуулж, чиг үүргийг давхардуулан хэрэгжүүлснээр томилолтын зардлыг шаардлагагүйгээр нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл үүссэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоохыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд зориулалтын дагуу зарцуулж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад тус байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар илрүүлсэн 301,838.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил бүхий асуудлын бүртгэлийг боловсруулж, 4,017.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 2 албан шаардлага, 2 зөвлөмжийг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар тус байгууллагад хүргүүлсэн 11,059.8 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 239,071.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 339,734.9 мянган төгрөгийн 8 зөвлөмжийн нийт хэрэгжилт 85.7 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	11,059.8	3	11,059.8	100.0
Албан шаардлага	3	239,071.4	1	152,791.4	33.3
Зөвлөмж	8	339,734.9	8	339,734.9	100.0
Нийт дүн	14	50,426.50	12	503,586.1	85.7

Өмнөх онд өгсөн 2 албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаа асуудлыг дараах байдлаар шийдвэрлэв. Үүнд:

1. Үндэсний аудитын газарт төсөв захирагчийн тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг иж бүрэн ирүүлээгүй зөрчилд хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, давтан гаргасан асуудалд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх;
2. Мөн өмнөх онд төсөвт тусгагдаагүй арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчлийг давтан гаргасан асуудалд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр байгаа боловч эрх бүхий албан хаагчид оны эцэст солигдсон тул хариуцлага тооцох боломжгүй нөхцөл байдал үүсч, шинээр томилогдсон төсөв захирагчид албан шаардлага хүргүүлэх-

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Агентлагийн бүтцэд хэлтэс хэлбэрээр батлагддаг Улсын бүртгэлд байгууллагын регистрын дугаар, гэрчилгээ аваагүй нийслэл, орон нутгийн хэлтсүүдийг Нийтийн ил тод байдлын тухай хуулийн 32¹.6-д "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нийслэл, орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийн дарга нь тус байгууллагад ажиллах албан хаагчдыг томилж, чөлөөлнө." гэж заасан нь хэлтсийн дарга нарын эрх хэмжээг хэтрүүлэн олгосон. Мөн хэлтсийн дарга нарыг сайд томилж, чөлөөлж байгаа нь байгууллагын дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог бууруулах эрсдэлтэй байгаа тул дээд шатны төсвийн захирагчийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

Мөн дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд,

- Байгууллагын ашигладаг санхүүгийн программ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бүрэн шинэчлэл хийгдсэн эсэх;
- Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар", "Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал"-ыг төсвийн гүйцэтгэл, тайлагналдаа хэрэгжүүлж ажилласан эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,493,605.0 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Тус байгууллагын 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаар баталгаажсан санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн дүнгүүдийг зөрүүтэй тайлагнасан байна. Үүнд:
 - Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл- Татаас санхүүжилтийн авлага болон байгууллагад төлөх өглөгийг 421.3 мянган төгрөгөөр дутуу,
 - Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүн- Үндсэн цалингийн зардлыг 1,399.2 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны зардлыг 2,064.2 мянган төгрөгөөр тус тус илүү;
 - Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх үеийн дүн-Бусад орлогыг 977.8 мянган төгрөг, байрны түрээсийн зардлыг 152,755.9 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал 23,304.8 мянган төгрөгөөр тус тус дутуу, гэрэл цахилгааны зардлыг 5,923.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 33,004.8 мянган төгрөгөөр тус тус илүү;
 - Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүн- Байрны түрээсийн зардал 27,959.6 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал 17,298.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 56,480.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, байрны түрээсийн зардлыг 45,258.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсөвт төвлөрүүлсэн 905,751.5 мянган төгрөгийг цэвэрлэж тайлагнаагүй;
3. Мөнгөн гүйлгээний тайланд урсгал төсвөөс бэлтгэсэн 2,550.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардлыг тусгаагүй;
4. Тайлант онд гэрээгээр 3 аж ахуйн нэгжээс худалдан авсан 25,986.8 мянган төгрөгийн лицензыг шууд зардлаар тайлагнасан байна. Үүнд:
 - Текпрос ХХК-тай 1 жилийн хугацаатай 120 ширхэг антивирус программын лиценз худалдан авах гэрээ байгуулж 12,000.0 мянган төгрөг;
 - Microsoft visio professional 1 жилийн хугацаатай лиценз /процессийн зураг зурах зорилгоор/ худалдан авах гэрээ байгуулж 2,987.0 мянган төгрөг;
 - Могул ХХК-аас 1 жилийн хугацаатай лицензийн /хэрэглээний 16 ширхэг программ/ худалдан авах гэрээ байгуулж 10,999.8 мянган төгрөгийг тус тус бүртгэсэн.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг”, санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй тул алдааг аудитын явцад бүрэн залрууллаа.

Аудитаар нийт 283,286.7 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс, 3,685.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 231,600.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 48,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 283,286.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 204,371.3 мянган төгрөгөөр давсан тул **“Хязгаарлалттай”** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаанаас 12 албан хаагчид нийт 3,685.9 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:" 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий албан хаагчдад илүү тооцож олгосон цалин 3,685.9 мянган төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой:

Илрүүлэлт 1: Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс 102,764.8 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь дараа жилийн төсөвт төлөвлөгдөөгүй зардал гаргах, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлага алдагдах эрсдэлтэй байна. Үүнд:

- УБ Каса Капитал ХХК-тай 2025 оны 1 дүгээр сараас 1 жилийн хугацаатай сард 16,746.0 мянган төгрөг төлөхөөр түрээсийн гэрээ байгуулсан боловч төсвийн төсөлд төлөвлөж тусгаагүй, төсөвт тодотголоор зардал нэмж батлагдаагүй байхад тайлант оны дундуур буюу 7 дугаар сард түрээслүүлэгч талтай харилцан тохиролцож, түрээсийн төлбөрийг 7,954.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаас 24,700.4 мянган төгрөг;
- Урсгал зардлаас өглөг үүсгэж 3,600.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
- Засгийн газрын авто баазад томилолтын тооцоог тухай бүр хийж төлбөр тооцоог гүйцэтгээгүйгээс 74,464.5 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-т "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн асуудлыг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Төсөвт төсөлд төлөвлөөгүй, батлуулаагүй зардлыг санхүүжүүлж нийт 88,336.0 мянган төгрөгийг зарцуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Хөвсгөл аймгийн цахим үйлчилгээний цэгийн урсгал засварын ажилд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 19,221.0 мянган төгрөг олгосон;

- Байгууллагын дотоод нөөц боломжоо ашиглан өөрөө гүйцэтгэх боломжтой судалгааг хувийн хэвшлийн компаниар гүйцэтгүүлж мэргэжлийн үйлчилгээний төлбөрөөс 18,500.0 мянган төгрөгийн зардал гаргасан. Мөн гэрээнд тусгагдсан төрийн үйлчилгээний мэдээллийг нэгтгэх, судалгаа хийх, тайлан боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн хүлээлцээгүй;
- Спортын арга хэмжээ зохион байгуулахад 9,935.0 мянган төгрөг;
- Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын тушаалаар дотоод томилолтын зардлаас зайлшгүй шаардлагатай бус 40,680.0 мянган төгрөгийн зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд: "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги" хэлэлцүүлэх анхдугаар чуулганд даргын А/07 дугаар тушаалаар 34,400.0 мянган төгрөг, "DroneX Mongolia-2025" нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон) жолоодлогын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахтай холбогдуулан даргын А/29 дүгээр тушаалаар 6,280.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын "Урсгал засвар" ангиллын тайлбарт "Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна", мөн "Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж" ангиллын тайлбарт "Байгууллага гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авахад төлөх (2108)-д зааснаас бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжууд энд хамаарна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төлөвлөж, батлуулаагүй арга хэмжээг санхүүжүүлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шаадлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, тэвчиж болох нийт 40,500.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Нандин оргил ухаан нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаас албан хаагчдын сэтгэл зүй, хэрэглээний программ, бусад ур чадварыг олгох сургалтад, гэрээ дүгнэсэн акт, тайлангүйгээр 15,000.0 мянган төгрөг;
- Өөрийн чиг үүрэгт хамааралгүй процессын дахин инжерчлэл сургалтын үйлчилгээний төлбөрт, гэрээ дүгнэсэн акт, тайлангүйгээр 16,600.0 мянган төгрөг;
- Ажил үйлчилгээний шаардлага, харьцуулсан үнийн судалгаа, хийсэн ажлын тайлангүйгээр хурал цуглаан зохион байгуулахад 8,900.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, тэвчиж болох зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаадлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 48,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл. "Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах", 2/ илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгссөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТЦҮЗГ-ын 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаар баталгаажсан санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн дүнгүүдийг зөрүүтэй тайлагнасан байна. Үүнд: 1. Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл- Татаас санхүүжилтийн авлага болон байгууллагад төлөх өглөгийг 421.3 мянган төгрөгөөр дутуу, 2. Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүн- Үндсэн цалингийн зардлыг 1,399.2 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны зардлыг 2,064.2 мянган төгрөгөөр тус тус илүү; 3. Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх үеийн дүн-Бусад орлогыг 977.8 мянган төгрөг, байрны түрээсийн зардлыг 152,755.9 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал 23,304.8 мянган төгрөгөөр тус тус дутуу, гэрэл цахилгааны зардлыг 5,923.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 33,004.8 мянган төгрөгөөр тус тус илүү; 3. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүн- Байрны түрээсийн	1	503,980.0			1	503,980.0	1	503,980.0				

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

зардал 27,959.6 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал ариутгал 17,298.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 56,480.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, байрны түрээсийн зардлыг 45,258.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан байна.												
Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсөвт төвлөрүүлсэн 905,751.5 мянган төгрөгийг цэвэрлэж тайлагнаагүй байна.	1	905,751.5	1	905,751.5			1	905,751.5				
Мөнгөн гүйлгээний тайланд урсгал төсвөөс бэлтгэсэн 2,550.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардлыг тусгаагүй байна.	1	2,550.0	1	2,550.0			1	2,550.0				
Тайлант онд гэрээгээр 3 аж ахуйн нэгжээс худалдан авсан 25,986.8 мянган төгрөгийн лицензыг шууд зардлаар тайлагнасан байна. Үүнд: 1. Текпрос ХХК-тай 1 жилийн хугацаатай 120 ширхэг антивирус программын лиценз худалдан авах гэрээ байгуулж 12,000.0 мянган төгрөг /2025.11.10/; 2. Microsoft visio professional 1 жилийн хугацаатай лиценз /процессийн зураг зурах зорилгоор/ худалдан авах гэрээ байгуулж 2,987.0 мянган төгрөг /2025.11.19/ 3. Могол ХХК-аас 1 жилийн хугацаатай лицензийн /хэрэглээний 16 ширхэг программ/ худалдан авах гэрээ байгуулж 10,999.8 мянган төгрөгийн /2025.06.18, 24/	1	25,986.8			1	25,986.8	1	25,986.8				

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ерөнхий журналд 55,336.6 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэж, тайлагнасан байна.	1	55,336.6			1	55,336.6	1	55,336.6				
Дүн	5	1,493,604.9	2	908,301.5	3	585,303.4	5	1,493,604.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс 102,764.8 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь дараа жилийн төсөвт төлөвлөгдөөгүй зардал гаргах, мөнгөн хөрөнгийн зохистой удирлага алдагдах эрсдэлтэй байна. Үүнд: 1. УБ Каса Капитал ХХК-тай 2025 оны 1 дүгээр сараас 1 жилийн хугацаатай сард 16,746.0 мянган төгрөг төлөхөөр түрээсийн гэрээ байгуулсан боловч төсвийн төсөлд төлөвлөж тусгаагүй, төсөвт тодотголоор зардал нэмж батлагдаагүй байхад тайлант оны дундуур буюу 7 дугаар сард түрээслүүлэгч талтай харилцан тохиролцож, түрээсийн төлбөрийг 7,954.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаас 24,700.4 мянган төгрөг; 2. Урсгал зардлаас өглөг үүсгэж 3,600.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн; 3. Засгийн газрын авто баазад томилолтын тооцоог тухай бүр хийж төлбөр тооцоог гүйцэтгээгүйгээс 74,464.5 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	102,764.8			1	102,764.8						
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 48,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн цаашид ашиглах хугацаа,	1	48,000.0						1	48,000.0			

үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.										
Төсөвт төсөлд төлөвлөөгүй, батлуулаагүй зардлыг санхүүжүүлж нийт 88,336.0 мянган төгрөгийг зарцуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилаагаагүй байна. Үүнд: 1. Хөвсгөл аймгийн цахим үйлчилгээний цэгийн урсгал засварын ажилд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 19,221.0 мянган төгрөг олгосон; 2. Байгууллагын дотоод нөөц боломжоо ашиглан өөрөө гүйцэтгэх боломжтой судалгааг хувийн хэвшлийн компаниар гүйцэтгүүлж мэргэжлийн үйлчилгээний төлбөрөөс 18,500.0 мянган төгрөгийн зардал гаргасан. Мөн гэрээнд тусгагдсан төрийн үйлчилгээний мэдээллийг нэгтгэх, судалгаа хийх, тайлан боловсруулах ажлыг хийж гүйцэтгэж хүлээлцээгүй; 3. Спортын арга хэмжээ зохион байгуулахад 9,935.0 мянган төгрөг; 4. ТЦҮЗГ-ын даргын тушаалаар дотоод томилолтын зардлаас зайлшгүй шаардлагатай бус 40,680.0 мянган төгрөгийн зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд: "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги" хэлэлцүүлэх анхдугаар чуулганд даргын А/07 дугаар тушаалаар 34,400.0 мянган төгрөг, "DroneX Mongolia-2025" нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон) жолоодлогын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахтай холбогдуулан даргын А/29 дүгээр тушаалаар 6,280.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	88,336.0			1	88,336.0				
Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаанаас 12 албан хаагчид нийт 3,685.9 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	1	3,685.9	1	3,685.9						
Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, тэвчиж болох нийт 40,500.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: 1. Нандин оргил ухаан НҮТББ-ээс албан хаагчдын сэтгэл зүй, хэрэглээний программ, бусад ур чадварыг олгох	1	40,500.0			1	40,500.0				

сургалтад 15,000.0 мянган төгрөг, гэрээ дүгнэсэн акт, тайлангүй; 2. Өөрийн чиг үүрэгт хамааралгүй процессын дахин инжерчлэл сургалтын үйлчилгээний төлбөрт 16,600.0 мянган төгрөг, гэрээ дүгнэсэн акт, тайлангүй; 3. Ажил үйлчилгээний шаардлага, харьцуулсан үнийн судалгаа, хийсэн ажлын тайлангүйгээр хурал цуглаан зохион байгуулахад 8,900.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.										
Дүн	5	283,286.7	1	3,685.9	3	231,600.8	1	48,000.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авалтыг хугацаанд нь зохион байгуулж чадаагүйгээс НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн төслийн санхүүжилтээс 34,100.0 мянган төгрөг, улсын төсвөөс 515,753.0 мянган төгрөг, нийт 549,853.0 мянган төгрөгийн шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч чадалгүй төсвийг буцаан татуулсан байна.	1	549,853.0	1	549,853.0		
Үндэсний аудитын газарт 2025.01.26-ны өдрийн 01/129 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлангийн иж бүрдэлд Төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайлан болон хуулиар баталсан холбогдох тайлан мэдээг ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	1	-		
Агентлагийн бүтцийн нэгжийн 21 аймагт салбартай бөгөөд салбар бүрд 3–5 үйлчилгээний ажилтан ажилладаг. Цахим хөгжлийг иргэдэд мэдээлэл түгээх ажлыг гүйцэтгэх боломжтой байхад үндсэн салбарын ажилтнуудыг орон нутагт мэдээлэл түгээх зорилгоор дотоод томиллоор олон удаа явуулж, чиг үүргийг давхардуулан хэрэгжүүлснээр томилолтын зардлыг шаардлагагүйгээр нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.	1	-			1	-
Дүн	3	549,853.0	2	549,853.0	1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 225/С0111333

Улаанбаатар хот

САГ-2026/219/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэртээ. Үүнд:

Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс 102,764,847.00 /Нэг зуун хоёр сая долоон зуун жаран дөрвөн мянга найман зуун дөчин долоон/ төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь дараа жилийн төсөвт төлөвлөгдөөгүй зардал гаргах, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлага алдагдах эрсдэлтэй байна. Үүнд:

- УБ Каса Капитал ХХК-тай 2025 оны 1 дүгээр сараас 1 жилийн хугацаатай сард 16,746,000.00 /Арван зургаан сая долоон зуун дөчин зургаан мянган/ төгрөг төлөхөөр түрээсийн гэрээ байгуулсан боловч төсвийн төсөлд төлөвлөж тусгаагүй, төсөвт тодотголоор зардал нэмж батлагдаагүй байхад тайлант оны дундуур буюу 7 дугаар сард түрээслүүлэгч талтай харилцан тохиролцож, түрээсийн төлбөрийг 7,954,400.00 /Долоон сая есөн зуун тавин дөрвөн мянга дөрвөн зуун/ төгрөгөөр нэмэгдүүлж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаас 24,700,400.00 /Хорин дөрвөн сая долоон зуун мянга дөрвөн зуун/ төгрөг;
- Урсгал зардлаас өглөг үүсгэж 3,600,000.00 /Гурван сая зургаан зуун мянган/ төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
- Засгийн газрын авто баазад томилолтын тооцоог тухай бүр хийж төлбөр тооцоог гүйцэтгээгүйгээс 74,464,497.00 /Далан дөрвөн сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга дөрвөн зуун ерэн долоон/төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-т "төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгаж биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Борхүү), ахлах нягтлан бодогч (Г.Долгорсүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 226/С0111333

Улаанбаатар хот

САГ-2026/219/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөвт төсөлд төлөвлөөгүй, батлуулаагүй зардлыг санхүүжүүлж нийт 88,336,000.00 /Наян найман сая гурван зуун гучин зургаан мянган/ төгрөгийг зарцуулж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Хөвсгөл аймгийн цахим үйлчилгээний цэгийн урсгал засварын ажилд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 19,221,000.00 /Арван есөн сая хоёр зуун хорин нэгэн мянган/ төгрөг олгосон;
- Байгууллагын дотоод нөөц боломжоо ашиглан өөрөө гүйцэтгэх боломжтой судалгааг хувийн хэвшлийн компаниар гүйцэтгүүлж мэргэжлийн үйлчилгээний төлбөрөөс 18,500,000.00 /Арван найман сая таван зуун мянган/ төгрөгийн зардал гаргасан. Мөн гэрээнд тусгагдсан төрийн үйлчилгээний мэдээллийг нэгтгэх, судалгаа хийх, тайлан боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн хүлээлцээгүй;
- Спортын арга хэмжээ зохион байгуулахад 9,935,000.00 /Есөн сая есөн зуун гучин таван мянган/ төгрөг;
- Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын тушаалаар дотоод томилолтын зардлаас зайлшгүй шаардлагатай бус 40,680,000.00 /Дөчин сая зургаан зуун наян мянган/ төгрөгийн зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд: "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги" хэлэлцүүлэх анхдугаар чуулганд даргын 2025 оны А/07 дугаар тушаалаар 34,400,000.00 /Гучин дөрвөн сая дөрвөн зуун мянган/ төгрөг, "DroneX Mongolia-2025" нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон) жолоодлогын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахтай холбогдуулан даргын 2025 оны А/29 дүгээр тушаалаар 6,280,000.00 /Зургаан сая хоёр зуун наян мянган/ төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын "Урсгал засвар" ангиллын тайлбарт "Байгууллага өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлс энд хамаарна", мөн "Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж" ангиллын тайлбарт "Байгууллага гуравдагч этгээдийн багц

үйлчилгээг худалдан авахад төлөх (2108)-д зааснаас бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжууд энд хамаарна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөвт төлөвлөж, батлуулаагүй арга хэмжээг санхүүжүүлж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Борхүү), ахлах нягтлан бодогч (Г.Долгорсүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 227/СОИИ333

Улаанбаатар хот

САГ-2026/219/КА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, тэвчиж болох нийт 40,500,000.00 /Дөчин сая таван зуун мянган/ төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Нандин оргил ухаан нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаас албан хаагчдын сэтгэл зүй, хэрэглээний программ, бусад ур чадварыг олгох сургалтад, гэрээ дүгнэсэн акт, тайлангүйгээр 15,000,000.00 /Арван таван сая/ төгрөг;
- Өөрийн чиг үүрэгт хамааралгүй процессын дахин инженерчлэл сургалтын үйлчилгээний төлбөрт, гэрээ дүгнэсэн акт, тайлангүйгээр 16,600,000.00 /Арван зургаан сая зургаан зуун мянган/ төгрөг;
- Ажил үйлчилгээний шаардлага, харьцуулсан үнийн судалгаа, хийсэн ажлын тайлангүйгээр хурал цуглаан зохион байгуулахад 8,900,000.00 /Найман сая есөн зуун мянган/ төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,"; 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, тэвчиж болох зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Борхүү), ахлах нягтлан бодогч (Г.Долгорсүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

(Handwritten signatures and stamps)

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-40.Docx

1526180654



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 229/СО111333

Улаанбаатар хот

САГ-2026/219/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/129 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлангийн иж бүрдэлд төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайлан болон хуулиар баталсан бусад холбогдох тайлан мэдээг ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.", 54.5.1-т "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/", 54.5.3-т "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл", 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан", 54.5.5-т "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө". Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заагдсан бүрэлдэхүүнээр ирүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Борхүү), ахлах нягтлан бодогч (Г.Долгорсүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 228/СО111333

Улаанбаатар хот

САГ-2026/219/НА-СТН-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авалтыг хугацаанд нь зохион байгуулж чадаагүйгээс Нэгдсэн Үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн төслийн санхүүжилтээс 34,100,000.00 /Гучин дөрвөн сая нэг зуун мянган/ төгрөг, улсын төсвөөс 515,753,000.00 /Таван зуун арван таван сая долоон зуун тавин гурван мянган/ төгрөг, нийт 549,853,000.00 /Таван зуун дөчин есөн сая найман зуун тавин гурван мянган/ төгрөгийн шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч чадалгүй төсвийг буцаан татуулсан байна.


Энэ нь төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38-д "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийн хүрээнд, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан, байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд, хариуцлагатай зохион байгуулж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Борхүү), ахлах нягтлан бодогч (Г.Долгосүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-40.Docx

1526180656



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 36/С0111333

Улаанбаатар хот

САГ-2026/219/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаанаас хавсралтад дурдсан 12 албан хаагчид нийт 3,685,883.50 /Гурван сая зургаан зуун наян таван мянга найман зуун наян гурван төгрөг тавин мөнгө/ төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:" 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хавсралтад дурдсан 12 албан хаагчдад илүү тооцож олгосон цалин 3,685,883.50 /Гурван сая зургаан зуун наян таван мянга найман зуун наян гурван төгрөг тавин мөнгө/ төгрөгийг ахлах нягтлан бодогч (Г.Долгорсүрэн)-ээр төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Борхүү)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Т.БААСАНЦЭНД
Б.ТЭГШСҮРЭН